

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН
ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ИРГЭД ХАРЬЯАЛАЛ
ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ
АВАХ БОЛОМЖ БҮРДСЭН БАЙНА.**

АУДИТЫН КОД: : ХӨА-2023/19-21-ШТА-ГА

**Хөвсгөл аймаг
2023 он**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: Davaadoriz@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр

Утас: 89306788 Цахим хаяг: Otgonbayard@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: Gurbazarn@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил

Утас: 99039344 Цахим хаяг: Munkh-Orgill@audit.gov.mn

**Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.**

https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА	Хуудас
Товчилсон үгийн жагсаалт	4
Аудитын зорилт:	7
Аудитын хамарсан хүрээ:	7
Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:	7
Аудитын ерөнхий мэдээлэл:	8
А.1 Хөвсгөл аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт хэрэгжсэн байна.	9
<i>А.1.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж ажилласан байна.</i>	9
<i>А.1.2. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн хууль, тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.</i>	9-10
<i>А.1.3. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгал төлсөн иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана байгаагаас үл шалтгаалан төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах боломж бүрдэж бодит үр дүн гарсан байна.</i>	11-12
Б.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөөгүй боловч санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.	13
<i>Б.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлыг үндэслэлгүйгээр төлөвлөснөөс 2022 онд орлого 36.5 хувиар тасарч зардал 2.4 дахин их гарсан байна.</i>	13-14
<i>Б.1.2. ЭМДХ нь санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж төлбөрийг олгосон боловч сумын эрүүл мэндийн төвд нэг иргэнээр тооцож олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.</i>	14-15
<i>Б.1.3. ЭМДХ- нь дутуу орон тоог бүрдүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, чанар төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шаардлага хангасан хүний нөөц дутмаг байна.</i>	15
<i>Б.1.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу зохион байгуулсан байна.</i>	16
<i>Б.1.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж ажилласан боловч, гэрээний хэрэгжилтийг бүрэн үнэлээгүй байна.</i>	17
<i>Б.1.6. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг зарим эрүүл мэндийн төвүүд үр ашиггүй зарцуулсан байна</i>	17-20
Б.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй авах боломж бүрдсэн.	20

Б.2.1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь лавлагаа шатлалын буюу хавдрын мэс заслын тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлснээр иргэд түргэн шуурхай, цаг алдалгүй тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	20-21
Б.2.2. ЭМД-ын байгууллагаас авсан тусламж үйлчилгээ болон иргэнээс төлбөл зохих төлбөр зэрэг мэдээллийг агуулсан “e-daatgal” аппликэйшны ашиглалт хангалтгүйгээс иргэд шаардлагатай мэдээллээр хангагдаж чадахгүй байна.	21-22
Б.2.3. Даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хүртээмжтэй зохион байгуулаагүй байна.	22
Б.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт стандарт, журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.	22
Б.3.1. Бодлогын баримт бичигт тусгаасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүнг орон нутагт дүгнэх боломжгүй байна.	23
Б.3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд стандарт, журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.	23-24
Б.3.3. ЭМДЕГ нь 2022 онд чанарын үнэлгээ гүйцэтгэсэн боловч үр дүнг олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.	24
Аудитаар ҮАГ-т хүргүүлэх санал	25
Аудитын дүгнэлт	26
Аудитын зөвлөмж	27
Аудитын зөрчлийн нэгтгэл	28
Шалгагдагч байгууллагын санал	29-36
Хавсралт	37-40
Албан шаардлага	41-46

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДТХ	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДБ	Эрүүл мэндийн даатгалын байгууллага
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НД	Нийгмийн даатгал
НДБ	Нийгмийн даатгалын байгууллага
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
АНЭ	Аймгийн Нэгдсэн эмнэлэг
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/21

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Мөнх тулгуур, Рэнчинжугнай, Энх-Үрс, Цээнэ, Хүмүүн, Жаргалан, Оюу-Ундраа эмнэлгүүд болон Мөрөн сумын Энх-Үйлс, Дэлгэрмөрөн, Гурван гал, Хөвсгөл-Энэрэл, Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тус тус хүргүүлсүгэй.

4. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор(З.Даваадорж)-т үүрэг болгосугай.


6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер(Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

7. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР





“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ” ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	71/A2260468/ХӨА-2023/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
2	72/A2260468/ХӨА-2023/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
3	73/A2270469/ХӨА-2023/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
4	74/A2270469/ХӨА-2023/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
5	75/A2271129/ХӨА-2023/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
6	76/A2271129/ХӨА-2023/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай

--ooOoo--

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дугаар тушаалаар баталсан аудитын сэдвийг үндэслэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх,
- ❖ Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, 6 сум 1 тосгоны эрүүл мэндийн төв, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 9 хувийн эмнэлэг, түүврээр 3 эмийн сангийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулан нийт 28 эрүүл мэндийн байгууллага, 2021, 2022 оны олгосон 65.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 76.6%-ийг хамруулан гүйцэтгэв.

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашигласан.

Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, Д.Отгонбаяр аудитор Н.Гүрбазар,

Г.Ичинхорлоо, Л.Мөнх-Оргил нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Улсын хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1¹-т зааснаар эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл/цаашид ЭМДҮЗ гэх/, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар/цаашид ЭМДЕГ гэх/, орон нутагт Эрүүл мэндийн даатгал хэлтэс/цаашид ЭМДХ гэх/ гэсэн тогтолцоотой байна.

Тогтолцооны хувьд: Аймагт Эрүүл мэндийн даатгалын хэлтэс 3 орон тоогоор ажиллаж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжин үйл ажиллагаа явуулж байгаа төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад хяналт хэрэгжүүлэн, эрүүл мэндийн даатгалын сангийн талаарх төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого чиглэл, хууль, журмуудыг олон нийтэд таниулах, мэдээлэл сурталчилгааг даатгуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэх ажлыг гардан гүйцэтгэж байна. Үүнд: хэлтсийн дарга-1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 2. Тогтолцооны хувьд босоо тогтолцоотой байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэн, Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Санхүүжилтийн хувьд: Аймагт Эрүүл мэндийн даатгалын сан/цаашид ЭМДС гэх/-гаас Нэгдсэн эмнэлэг, 23 сум, тосгоны эрүүл мэндийн төв, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 9 хувийн эмнэлэг, 60 эмийн сан, 1 рашаан сувиллын газар нийт 99 эрүүл мэндийн байгууллагатай, гэрээ байгуулж, 90 байгууллагад эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг олгосон байна. Санхүүжилтийг 2021 оноос гүйцэтгэлд суурилсан хэлбэрээр олгож байна.

Харин өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг төлөвлөх, санхүүжүүлэхдээ дараах аргаар санхүүжүүлж байна.

Зураг №1



/Эх сурвалж: Азийн хөгжлийн банкны бэлтгэсэн анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилтийн мэдээлэл/

Нэг иргэнээр тооцсон нийт төсвийн 80 хувийг сар бүрийн эхэнд эрүүл мэндийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс, үлдсэн 20 хувийг олгохдоо гүйцэтгэлийг хянаж дараа сарын 20-ны дотор эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль” болон ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолд тус тус заасан байна. Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулахыг хориглосон байна.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2021 онд 5.6 тэрбум, 2022 онд 6.9 тэрбум төгрөгийн ЭМД-ын орлогыг төвлөрүүлж ажилласан байна.

¹ 14.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэнэ.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс 2021 онд давхардсан тоогоор 511.8 мянган хүний 26.5 тэрбум, 2022 онд 434.3 мянган хүний 39.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хянаж эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.

БҮЛЭГ А:

САНХҮҮЖИЛТИЙГ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ОЛГОХ ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ ТӨЛСӨН ИРГЭН МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХААНА БАЙГААГААС ҮЛ ШАЛТГААЛАН ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БОЛОМЖ БҮРДСЭН БАЙНА.

А.1. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААР ТУСГАСАН ЗОРИЛТ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

А.1.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгал, санхүүжилтийн талаар Хөвсгөл аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дараах байдлаар заасан байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.5-д “Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг оновчтой болгох, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.”,
2. Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.9-т “ Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.”

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгал, санхүүжилтийн талаар тавьсан зорилтууд нь Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт “Алсын хараа-2050”, дунд хугацааны бодлогын баримт бичиг “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус нийцсэн байна.

Аудитад хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэхтэй холбоотой ЭМДҮЗ, ЭМДЕГ-аас гаргасан тогтоол дүрэм, журам ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь тогтсон нэг ойлголттой болоход хүндрэл учруулж байгаа тухай эрүүл мэндийн байгууллагууд санал илэрхийлж байна. **Тухайлбал:** Төлбөрийн хэмжээ, түүнийг санхүүжүүлэх арга, журам, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, чанар, төлбөрийн гэх мэт олон дүрэм, журам 2021, 2022 онуудад 1-3 удаа шинэчлэн батлагдсан бөгөөд зарим журмыг 2023 онд дахин шинэчлэн батлахаар эрүүл мэндийн байгууллагуудаас санал авч байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээний уялдаа холбоо, хэрэгжилт хангагдсан байна.

А.1.2. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хууль, тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд тусгасан байна.

Аймгийн Эрүүл мэндийн хэлтсийн даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 21 арга хэмжээг 97.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан ба ЭМДЕГ-ын дарга 96 хувьтай үнэлсэн байна.

Аудитаар аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст хамаарах заалтыг сонгон авч хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №1

№	Хуулийн заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Хэрэгжсэн байдал	Тайлбар
---	---------------	-----------------------	------------------	---------

1	16.1.2	Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах;	Бүрэн хэрэгжүүлээгүй	Тайлангийн Б.1.1 дэх хэсгийн хэсгээс үзнэ үү
2	16.1.3	Даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээ худалдан авах даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;	Бүрэн хэрэгжүүлээгүй	Тайлангийн Б.1.5 дахь хэсгээс үзнэ үү.
3	16.1.4	Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эмийн сангаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн	Тайлангийн Б.1.4 дахь хэсгээс үзнэ үү.
4	16.1.5	Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;	Хэрэгжүүлсэн	Тайлангийн Б.1.3 дахь хэсгээс үзнэ үү.
5	16.1.7	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавих;	Бүрэн хэрэгжүүлээгүй	Тайлангийн Б.1.2 дахь хэсгээс үзнэ үү
6	16.1.9	Үндэсний зөвлөл болон бусад эрх бүхий этгээдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээ, тооцоо, судалгаагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	Хэрэгжүүлсэн	Тайлангийн Б.1.1 дэх хэсгээс үзнэ үү
7	16.1.11	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах;	Бүрэн хэрэгжээгүй	Хүснэгтийн доод хэсэгт тайлбарлав
8	16.1.12	Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;	Санал гомдол ирээгүй	2022 оны гүйцэтгэлийн тайлангаас мэдээлэл авав
9	16.1.17	Даатгуулагчийг энэ хуулийн 9.4-т заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах товлосон хугацааг даатгуулагчид тухай бүр урьдчилан мэдэгдэж байх;	Хэрэгжүүлсэн	Тайлангийн Б.2.3 дахь хэсгээс үзнэ үү


Дээрх хүснэгтээс харахад хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт 55 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хийсэн байна. Үүнд:

- Аймгийн хэмжээнд сум баг бүрээр эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар аймгийн Засаг дарга, нийгмийн бодлогын хэлтсийн дарга нартай уулзаж сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 08 дугаар албан даалгавраар чиглэл хүргүүлсэн,
- Иргэдэд эрүүл мэндийн даатгалын хэлтсийн FB /744 дагагчтай/ хуудсаар мэдээ мэдээллийг нээлттэй ил тод хүргэсэн.

Аудитын хугацаанд 550 иргэнийг хамруулан цахимаар явуулсан санал асуулгын дүнгээр

Зураг №2



“Мэдээллийн хүртээмжийг хэрхэн үнэлж байна вэ?” гэсэн асуултад санал асуулгад оролцсон иргэдийн 32.1 хувь нь муу, 47.8 хувь нь дунд, 15 хувь нь сайн, 3.4 хувь нь маш сайн, 1.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол “Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хүртээмжийг хэрхэн үнэлж байна

вэ? гэсэн асуултад судалгаанд оролцсон иргэдийн 79.9 хувь нь дундаас доогуур үнэлгээ өгсөн нь мэдээ, мэдээллийг иргэдэд хангалттай хэмжээнд хүргэж чадахгүй байх эрсдэл байгааг харуулж байна.

Тус хэлтсийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг хянахад ажлын байрны тодорхойлолтын 4-р зорилтын 3²(тухайлбал: 2022 оны гэрээг бүрэн дүгнээгүй), 5 дугаар зорилтын 1³ (тухайлбал: Орлогын төлөвлөгөө 36.5 хувиар тасарсан) дахь зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт 55 хувь, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргаар дүгнүүлж баталгаажуулаагүй зэргээс үндэслэн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хууль, тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж дүгнэлээ.

А.1.3. Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгал төлсөн иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана байгаагаас үл шалтгаалан төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.

УИХ 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого⁴-д”, бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.22⁵-д гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжих зорилт тусгаж Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчид дараах ололттой талууд бий болсон байна. **Үүнд:**

² Гэрээний хэрэгжилтийг гэрээнд заасан хугацаанд дүгнэх, гэрээний талуудыг мэдээллээр хангах, тайлагнах, эргэх холбоо тогтоох, гэрээний үүргийг ноцтой зөрчсөн тохиолдолд гэрээнд заасны дагуу арга хэмжээг төлөвлөж, хэлтсийн даргаад танилцуулах, шийдвэрлүүлэх,

³ Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт, зардлын гүйцэтгэлийг хангуулах, тайлагнах

⁴ Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна.

⁵ Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ.

- Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.24⁶-д заасны дагуу нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн.
- Эрүүл мэндийн төвүүдэд 2019, 2022 онуудад ирүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол харьцуулан үзэхэд буурсан үзүүлэлттэй.
- Эрүүл мэндийн байгууллагын эмч, эрүүл мэндийн ажилтны дотоод зохион байгуулалт сайжирч сумын эрүүл мэндийн төвийн их эмчид төвлөрч байсан ачаалал буурсан байна.



Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр иргэнд дараах сул талууд бий болох эрсдэлтэй байна. **Үүнд:**



- Эрүүл мэндийн даатгал төлөөгүй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй орхигдох,
- Эрүүл мэндийн байгууллага нь санхүүжилтээ бүрдүүлэхийн тулд эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ зөвхөн даатгалтай иргэдэд чиглүүлэх,
- Иргэнд шаардлагагүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх магадлалтай гэх мэт.

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгал төлсөн иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана байгаагаас үл шалтгаалан төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авч болох бодит үр дүн гарсан байна.

Даатгал төлсөн иргэнд эрүүл мэндийн даатгалын тогтолцоо эерэг сайн талтай хэдий ч өрхийн орлого болон ажилгүйдлээс шалтгаалан эрүүл мэндийн даатгал төлөх боломжгүй иргэнд эрүүл мэндийн байгууллагын “үүд хаалга хаалттай” болох магадлал байна.

Эрүүл мэндийн байгууллагын тухайд: Сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолд заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг авч байна.



Аймгийн төв, лавлагаа шатлалын эмнэлэгт ойрхон байрлалтай сумын иргэд лавлагаа шатлалын эмнэлгээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах тохиолдол нийтлэг байдаг тул лавлагаа шатлалын эмнэлэгт ойрхон байрлалтай сумын Эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилт дутагдах магадлалтай байна.

Иймд тухайн сумын эрүүл мэндийн төвд олгох нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг аймгийн төвөөс алслагдсан байдлын коэффициентын нийт санхүүжилтэд эзлэх хувийг харгалзан өөрчлөх нь зүйтэй байна.

Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгал төлсөн иргэн Монгол улсын нутаг дэвсгэрт хаана байгаагаас үл шалтгаалан гэрээт төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.

⁶ “эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” гэж хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх үйл ажиллагааг;

БҮЛЭГ Б:


НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, СУМ, ТОСГОН, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД НЬ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ЗАРЦУУЛАХГҮЙ БАЙНА.

Б.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БОЛОВЧ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГОСОН БАЙНА.

Б.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлыг төлөвлөхдөө хамрагдалтын төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөөгүй, 2022 онд орлого 36.5 хувиар тасарч зардал 2.4 дахин нэмэгдсэн байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021, 2022 оны төсвийг тухайн жилийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай” хуулиар баталж байна. Үүнээс Хөвсгөл аймагт Эрүүл мэндийн даатгалын сангаас хуваарилсан дүнг графикаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

График №1 /тэрбум төгрөг/



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулахдаа аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтэс болон Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс төсвийн төсөлд санал авдаггүй бөгөөд орлогоос давсан зардлыг төлөвлөж байгаа нь төсвийн тэнцвэр алдагдах, сангийн чөлөөт үлдэгдэл буурах эрсдэлтэй байгааг харуулж байна.

Сангийн орлого, зардал, хамрагдалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 2 жилээр харуулбал:

Хүснэгт №2 /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Орлого	5,562.7	5,645.1	-82.3	10,869.9	6,901.7	3,968.2
2	Зардал	12,548.3	26,472.2	-13,923.8	16,465.0	39,138.7	-22,673.7
3	Хамрагдалт	28,100	122,370		24,460	122,423	

Хүснэгтээс харахад 2021 оны орлого 82.3 сая төгрөгөөр давж биелсэн, 2022 оны орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлэн баталсан бөгөөд 3,968.2 сая төгрөгөөр орлого тасарсан, 2021 оны зарлага 13,923.8 сая төгрөгөөр хэтэрсэн, 2022 оны зарлага 22,673.7 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2022 оны хамралтын төлөвлөгөөг өмнөх оноос бууруулж, гүйцэтгэлээс доогуур баталсан байна.

Орлогын төлөвлөгөөг 2 дахин нэмэгдүүлэн баталсан асуудлыг холбогдох байгууллагаас тодруулахад “Сангийн яамнаас цалингийн өсөлт, аж ахуйн нэгжүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2019 оноос хойших нөхөн төлөлт болон сангийн зардалтай уялдуулан 2 дахин нэмэгдүүлж баталсан” гэж тайлбарласан.

Аудитаар орлого, зардал, хамрагдалтын төлөвлөгөөг дахин тооцоолоход дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- ❖ 2022 оны орлогын төлөвлөгөөг хамрагдалтын төлөвлөгөөтэй уялдуулан тооцож үзэхэд $24,460^7 \times 50.4^8 = 1,232.8$ сая төгрөг байгаа бөгөөд 226.0 сая төгрөгийн орлогыг дутуу төлөвлөсөн. /Хавсралт №1/

⁷ 2021 онд хамруулахаар төлөвлөсөн иргэний тоо

⁸ Эрүүл мэндийн даатгалаа өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн жилд төлдөг шимтгэлийн хэмжээ 2021 болон 2022 онуудад 50,400 төгрөг байсан.

- ❖ 2021 онд нийт малчдын 54.8 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулахаар төлөвлөж, 15.8 хувийг хамруулсан, 2022 онд нийт малчдын 43.1 хувийг хамруулахаар төлөвлөж, 14.1 хувийг хамруулсан.

Хүснэгт №3 /сая төгрөг/

№	Он	2021 он			2022 он		
		Статистик мэдээ	Төл	Гүйц	Статистик мэдээ	Төл	Гүйц
1	Малчин иргэний тоо	32,810	18,000	5,207	33,386	14,400	4,703

- ❖ ЭМДЕГ-аас баталсан ажил олгогч болон даатгуулагчийн төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг 2021 онд 1,384.1 сая төгрөг, 2022 онд 1,540.1 сая төгрөгөөр зөрүүтэй төлөвлөсөн. /Хавсралт №2/

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлыг төлөвлөхдөө орон нутгийн саналыг авахгүйгээр төлөвлөж баталснаар орлого тасарсан, хамрагдалтын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс шалтгаангүйгээр бууруулж баталсан, зөвхөн малчин иргэдийн хамрагдалтыг түүвэрлэн хянахад төлөвлөсөн хэмжээнээс 67,3-71,2 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулж чадаагүй байгаа зэрэг нь сангийн хөрөнгийн төлөвлөлт бодит тоо судалгаанд үндэслээгүй байгааг харуулж байна.

Б.1.2. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж олгосон боловч сумын эрүүл мэндийн төвд нэг иргэнээр тооцож олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын дагуу гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 онд 90 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан 26,472.2 сая төгрөг, 2022 онд нийт 71 байгууллагатай гэрээ байгуулж, 39,138.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгохоор тооцсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4 /сая төгрөг/				
Он	Байгууллагын тоо	Нэхэмжилсэн	Олгохоор тооцсон	Олгосон
2021	90	29,854.5	26,472.2	21,685.0
2022	71	41,637.3	39,138.7	43,926.0

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021, 2022 онуудад 28,398 хүний 5,848.9 сая төгрөгийн санхүүжилт хяналтаар хасагдсан байна. Үүнийг хүснэгтээр задалж

харуулбал:

Он	Хүснэгт №5 /сая төгрөг/					
	Хасалт					
	Системийн		Эмчийн		Байцаагчийн	
	хүний тоо	Дүн	хүний тоо	Дүн	хүний тоо	Дүн
2021	6,451	1,672.4	7,048	1,678.0	1,164	32.0
2022	7,872	1,263.0	6,403	1,181.9	984	53.6
Нийт	14,323	2,935.4	13,451	2,859.9	2,148	85.6

ЭМДХ-ээс санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын дагуу хянаж олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын 5 дугаар зорилтын 2⁹ дугаарт заасан чиг үүргийн хүрээнд 2021, 2022 оны эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын тайланг бэлтгэн, харилцагч эрүүл мэндийн байгууллагуудтай тооцоо нийлэн баталгаажуулж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Аудитаар 2022 оны зардлын тайланг хянаж үзэхэд сумын эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тайлангийн дүнг тулгаж үзэхэд 679.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Тайлагналын зөрүүг хүснэгтээр харуулбал:

⁹ “Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээг гаргах, хэлтсийн даргад танилцуулах”

Хүснэгт №6 /сая төгрөг/

№	Сумын ЭМТ-н анхан шатны санхүүжилт /Нэг иргэн/	ЭМДХ-ийн задаргаагаар	Гүйцэтгэлээр	Зөрүү
1	Нэг иргэний санхүүжилт	8,977.2	8,298.1	679.1

/эх сурвалж: Аймгийн ЭМДХ, ЭМГ-ын мэдээлэл/

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.2. “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” заалтуудад тус тус нийцэхгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж олгосон боловч сумын эрүүл мэндийн төвд нэг иргэнээр тооцож олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.

Б.1.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дутуу орон тоог бүрдүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, чанар төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шаардлага хангасан хүний нөөц дутмаг байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01 сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалаар эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан байна. Тус тушаалаар Хөвсгөл аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь Хэлтсийн дарга 1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 5, нийт 6 орон тоотойгоор баталсан байна.

Хөвсгөл аймгийн ЭМДХ-т хэлтсийн дарга-1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 2 нийт 3 орон тоотой байгаа ба батлагдсан орон тооны 50 хувиар үйл ажиллагаа явуулж байна. ЭМДХ-ийн албан хаагчдыг мэргэжлээр ангилан харуулбал:

Хүснэгт №7

№	Албан тушаал	Тоо	Мэргэжил
1	Хэлтсийн дарга	1	Их эмч
2	Чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн	2	Нягтлан бодогч
Нийт тоо		3	

Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод анагаах ухаан, бизнес ба удирдахуй, эрх зүй, эдийн засаг статистик гэсэн 4 мэргэжлийн аль нэгийг эзэмшсэн

байхаар заасан бөгөөд одоогоор 2 нягтлан бодогч чанар, төлбөрийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг хэлтсийн дарга буюу 1 их эмч гүйцэтгэж, эрүүл мэндийн чанар, төлбөрийн хяналтыг нягтлан бодогч мэргэжилтэй албан тушаалтнууд гүйцэтгэж байгаа нь дараах эрсдэлүүдийг дагуулах магадлалтай гэж үзлээ. Үүнд:

- ❖ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, эмнэл зүйн газар дээрх хяналт бүрэн хэрэгжихгүй байх,
- ❖ Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаагүй, ажлын ачаалал болон эрх мэдэл нэг дор төвлөрөх,

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дутуу орон тоог бүрдүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шаардлага хангасан хүний нөөц дутмаг байна.

Үйл ажиллагааны зардлын талаар: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын төсвийг эрүүл мэндийн даатгалын сангийн 2021, 2022 оны төсвийн тухай хуулиар нийт дүнгээр баталж, орон нутагт хуваарилдаггүй байна. ЭМДХ-нь бие даасан төсөвгүй бөгөөд үйл ажиллагааны зардлыг ЭМДЕГ-аас шууд зарцуулдаг байна. Иймд Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн зардлыг орон нутагт хянах боломжгүй байна.

Б.1.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу зохион байгуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулахдаа 2021, 2022 онуудад дараах журмуудыг мөрдлөг болгон ажилласан байна. Үүнд:

1. 2021 онд ЭМДҮЗ-ийн 2018 оны 09 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”,
2. 2022 онд ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-аар сонгон шалгаруулалтыг selection1818.mn цахим системээр ерөнхий болон тусгай шаардлагаар үнэлэн явуулж байна.

Сонгон шалгаруулалтын ерөнхий шаардлагыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-аар тодорхойлсон бол ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/48 дугаар тушаалаар “Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах тусгай шаардлага”-ыг баталсан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 онд 99, 2022 онд 71 нийт 170 төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулснаас, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс бусад 142 эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аудитаар нэгдсэн эмнэлэг болон 8 хувийн эмнэлгийн 2022 оны сонгон шалгаруулалтын цахим системд оруулсан мэдээллийг татан авч ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/48 дугаар тушаалаар баталсан “Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах тусгай шаардлага”-тай нийцэж буй эсэхийг хянахад гэрээ байгуулсан оношийн хамаарлын бүлэгт заагдсан шаардлагуудыг хангаж байна.

Иймд шалгаруулалтыг батлагдсан журам, шаардлагуудад нийцүүлэн зохион байгуулсан байна гэж дүгнэлээ.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төр, хувийн хэвшлийн удирдлагуудтай аудитын хугацаанд уулзаж ярилцахад сонгон шалгаруулалтыг цахимаар явуулахад дараах хүндрэл үүсэж байгаа талаар хэлж байна. Тухайлбал:

1. Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад орон нутгийн онцлог, ажлын туршлагыг үндэслэхгүй сонгон шалгаруулалтын нэмэлт шаардлага тавьсан нь төрийн эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлж, тухай хувийн эмнэлгээр байнга үйлчлүүлж ирсэн иргэдийн хүссэн эмнэлгээ сонгон ЭМД-аар үйлчлүүлэх боломжийг хаасан байна. **Тухайлбал:** Хөвсгөл аймгийн Ренчинжугнай эмнэлэг нь дотроор олон жил эмчилгээ эрхэлсэн, энэ чиглэлээр туршлагатай эмчтэй байхад дотрын зарим оношийн хамаарлын бүлгийн эмчилгээ хийхэд “хоол боловсруулах тогтолцоо судлалын төрөлжсөн мэргэжлийн эмч”-ийг тусгай шаардлага болгон тавьснаар дотрын зарим төрлийн эмчилгээний сонгон шалгаруулалтын шаардлагыг хангахгүй болж тус эмнэлгээр жил бүр үйлчлүүлдэг иргэд ЭМД-аар үйлчлүүлж чадахгүй болсон байна.
2. Тусгай шаардлагад *-ээр тэмдэглэгдсэн буюу “тусгай шаардлагад хамаарахгүй байж болно” гэсэн тэмдэглэгээтэй шалгуур үзүүлэлтийн материалыг цахим системд оруулах шаардлагагүй боловч оруулаагүй тохиолдолд материалыг хүлээж авахгүй байна. **Тухайлбал:** Ходоодны өмөн өвчинд хэвлийн хавдрын мэс заслын эмч, хавдрын туяа эмчилгээ судлалын эмч, ангиографи-дүрс оношилгооны эмч зэргийг **-ээр тодорхойлж аймгийн нэгдсэн эмнэлэгт хамаарахгүй байж болохоор заасан боловч сонгон шалгаруулалтын цахим программд эдгээр хүний нөөцийн мэдээллийг

оруулаагүй тохиолдолд илгээх үйлдэл нь идэвхэждэггүй, мэдээллийг хүлээн авдаггүй байна.

Б.1.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулсан боловч 2022 оны гэрээний хэрэгжилтийг бүрэн үнэлээгүй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 онд 99, 2022 онд 71 эрүүл мэнд тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулж ажилласан байна. Гэрээ байгуулсан байгууллагуудыг задалж харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №8

Он	Нэгдсэн эмнэлэг	Сум, тосгоны ЭМТ	Өрхийн ЭМТ	Хувийн эмнэлэг	Рашаан сувилал	Эмийн сан	Нийт
2021	1	23	5	9	1	60	99
2022	1	23	5	9	1	32	71

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг 2021 онд ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/12, 2020 оны 12 дугаар тушаалуудаар баталсан гэрээний үлгэрчилсэн загварын дагуу байгуулсан бол 2022 онд ЭМДҮЗ-ийн 2021 оны 13 тогтоолоор баталсан гэрээний үлгэрчилсэн загварын дагуу гэрээг байгуулсан байна.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/56 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулах журам”-ыг баталж төр хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 2022 оны гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Гэрээг дүгнэхдээ дараах журам, түүний шалгуур үзүүлэлтүүдийг баримтлан ажилласан байна. **Үүнд:**

1. ЭМДЕГ-ын 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ын дагуу 2021 оны өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн гэрээг 15 шалгуур үзүүлэлтээр, эмийн сангуудын гэрээг 18 шалгуур үзүүлэлтээр,
2. 2022 оны гэрээг ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах, гэрээний биелэлтийг үнэлэх журам”-ын дагуу 2022 оны эмийн сангуудын гэрээг 9 шалгуур үзүүлэлтээр.

Аймгийн ЭМДХ нь 2021 онд 28 өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон 51 эмийн сангийн, 2022 онд зөвхөн 28 эмийн сангийн гэрээг дүгнэж ажиллажээ. Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 2022 оны гэрээг журам шинэчлэгдэнэ гэсэн шалтгаанаар одоог болтол дүгнээгүй байна.

ЭМДХ нь гэрээг дүгнэхдээ батлагдсан шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргаар холбогдох баримт материалыг гаргуулан, тухайн байгууллагын удирдлагуудыг оролцуулж батлагдсан журмын дагуу дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулсан боловч 2022 оны гэрээний хэрэгжилтийг бүрэн үнэлээгүй байна.

Б.1.6. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгосон санхүүжилтээс 192.0 сая төгрөгийг шагнал урамшуулал, бэлэг дурсгал, биеийн тамирын болон нормын хувцас худалдан авч эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашгийг бууруулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний зардлын төлбөрт 2021 онд 26,472.2 сая төгрөг, 2022 онд 39,138.7 сая төгрөгийг тус тус олгосон байна. Олгосон санхүүжилтийг байгууллага тус бүрээр ангилан хавсралт №3 -д харуулав.

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлд “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасны дагуу Хөвсгөл аймагт нийт 5 өрхийн эрүүл мэндийн төв нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байна. Харин сумын эрүүл мэндийн төвүүд улсын төсвийн байгууллага байна.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь ижил чиг үүргийг хэрэгжүүлж байгаа боловч өмчийн хэлбэрийн хувьд ялгаатай байгаагаас орон тоо, бүтэц, цалин тогтоолт, хөрөнгийн зарцуулалтын хувьд ялгаатай байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9

№	Харьцуулсан үзүүлэлт	Өрхийн ЭМТ	Сумын ЭМТ
1	Өмчийн хэлбэр	Нөхөрлөл	Улсын төсвийн байгууллага
2	Үйл ажиллагааны чиглэл	Анхан шатны тусламж үйлчилгээ	Анхан шатны тусламж үйлчилгээ
3	Санхүүжилтийн хэлбэр	ЭМДС /нэг иргэн, тохиолдолд суурилсан/	ЭМДС /нэг иргэн, тохиолдолд суурилсан/
4	Удирдлагын томилгоо	Нөхөрлөлийн хурлын шийдвэр	Аймгийн ЭМГ-ын дарга, сумын ЗД нар зөвшилцөнө
5	Цалин	Нөхөрлөлийн хурлын шийдвэр	Засгийн газрын тогтоолоор
6	Төсвийн зарцуулалт	Нөхөрлөлийн хурлын шийдвэр	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд
7	Тусламж үйлчилгээ	4 багц	4 багц+Яаралтай+Түргэн тусламж+хэвтүүлэн эмчлэх

Хүснэгтэд дурдсан ялгааг тодруулбал:

1. Өрхийн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвийн цалин тогтоолтыг авч үзэхэд 700.0-1000.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.
2. Сумын эрүүл мэндийн төвүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд төсөв зарцуулан ажиллаж байхад өрхийн эрүүл мэндийн төвүүд нь зөвхөн нөхөрлөлийн хурлын шийдвэрээр хөрөнгө зарцуулж байна.

Аудитаар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт иргэдэд үр нөлөөтэй байгаа эсэх, сангийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй зүйлс илэрч байна. **Үүнд:**

- ❖ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь хувийн эмнэлэгт хэвтэх иргэдэд 13а маягтыг хүн бүрд олгодоггүйгээс иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт эдэлж чадахгүй, эсвэл хувийн эмнэлэг санхүүжилтээ авч чадахгүй байх чирэгдлийг үүсгэж байна.
- ❖ Мөрөн сумын өрхийн эрүүл мэндийн төвийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 40.2 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын 3.5¹⁰ дахь заалтыг зөрчсөн бөгөөд Хөвсгөл аймгийн Засаг дарга, эрүүл мэндийн газартай байгуулсан гуравласан гэрээний дөрөвдүгээр зүйлийн 4.1 Аймгийн Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ. 4.1.1¹¹, зургаадугаар зүйлийн 6.1 Төвийн дарга нь дараах үүргийг хүлээнэ. 6.1.15¹² дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.
- ❖ Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөр 35.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг тус тус зөрчсөн зөрчилд байгууллагаас ирүүлсэн санал тайлбарыг үндэслээд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

¹⁰ "Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд шилжүүлэхийг хориглоно"

¹¹ "Төвийг эмнэлгийн зориулалтын байраар хангаж, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангаагдах нөхцөлийг бүрдүүлэн, тогтмол зардлыг хариуцан, төсвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах"

¹² "Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тулгамдсан асуудлаа холбогдох байгууллагад тухай бүр тавьж шийдвэрлүүлэх"

- ❖ Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод ажилласан нийт албан хаагчдад 87.4 сая төгрөгийн урамшуулал олгохдоо гаргасан тушаал шийдвэр нь хууль эрх зүйн үндэслэл хангалтгүй, санхүүгийн анхан шатны нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹³ дахь заалтад нийцэхгүй байна.
- ❖ Эдийн засгийн ангиллаар хуваарилаагүй 2 тэрбум гаруй төгрөгийн төсвийг ямар нэгэн төрийн сангийн хяналтгүй, Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд хязгаарлагдахгүйгээр 5 ӨЭМТ-ийн дунд 1 нягтлан бодогч хариуцан зарцуулж байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/212 дугаар тушаалаар баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 4.2-т “Төвийг Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, түүнийг дагаж гарсан тогтоол, тушаал, шийдвэрийн дагуу санхүүжүүлж, хяналт тавина” гэж заасантай нийцэхгүй байна.
- ❖ ӨЭМТ-ийн дарга нар нь бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, шагнал урамшуулал олгох зэрэг шийдвэр гаргахдаа өөрөө өөртөө тушаал гарган байгууллагын төсвөөс зарцуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1¹⁴ дэх заалттай нийцэхгүй байна.
- ❖ Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь 1,277.6 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1¹⁵ дэх заалттай нийцээгүй байна.
- ❖ Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хэвтэн эмчлүүлсэн иргэнд өвчний түүх нээгээд 24 цаг болоход эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийн хэмжээ нь системээс шууд нийт дүнгээр бичигдэж байна. Ингэснээр нэг оношоор 1 хоног хэвтсэн, 7 хоног хэвтсэн 2 өөр гүйцэтгэлд ижил төлбөр олгож байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3¹⁶ дахь заалтад нийцэхгүй байна.
- ❖ Мөрөн сумын хувийн хэвшлийн эмнэлгүүдийн иргэнд үзүүлсэн нэмэлт үйлчилгээний 56.5 сая төгрөгийн төлбөрийн анхан шатны баримтууд нь хийгдсэн эмчилгээ, үйлчилгээг бүрэн нотолж чадахгүй байна.
ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор баталсан иргэний хариуцах төлбөр болон иргэнээс авсан төлбөрийг харьцуулан хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт №10 /сая төгрөг/

№	Эмнэлгийн нэрс	Хүний тоо	Иргэнээс авах ёстой		Иргэнээс авсан	Зөрүү
			Хамтын төлбөр	Сэргээн засах /Ойролцоогоор тооцсон/		
1	Хүмүүн ХХК	62	4.9	2.6	17.2	9.6
2	Ренчинжугнай ХХК	53	1.4	6.5	15.3	7.4
3	Оюу-Ундраа ХХК	127	4.3	10.1	27.3	12.8
4	Мөнхтулгуур ХХК	58	1.8	5.2	13.0	6.1
5	Жаргалан ХХК	46	5.5	-	10.4	4.7
6	Энх-Үрс ХХК	72	-	7.3	14.6	7.3
7	Цээнэ ХХК	58	4.9	-	13.5	8.5
	Нийт	476	22.8	31.7	111.0	56.5

¹³ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹⁴ Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно

¹⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

¹⁶ “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төсвийн сарын хуваарийг үндэслэн гүйцэтгэлээр тооцож олгох бөгөөд эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан гэрээний дагуу зардлын урьдчилгаа төлбөр олгож болно”

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹⁷, 13.6¹⁸, 13.7¹⁹ дахь заалтуудад тус тус нийцэхгүй байна.

- ❖ Мөрөн сумын хувийн эмнэлгүүд нь иргэнээс авч байгаа төлбөрөө байгууллагын дансаар дамжуулан авахгүй, хувийн дансаар авч байгаа нь Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49, А/118 дугаар тушаалын гуравдугаар зүйлд заасан эмч, эмнэлгийн ажилтны хориглох зүйл, 3.1.3²⁰ дахь заалттай нийцэхгүй байна.
- ❖ Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь эмчлүүлсэн иргэдээс гэрээнд заасан хамтын төлбөр аваагүй байна. 2021 оны эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжлэл, хамтын төлбөрийн орлогын байдалд түүврийн хяналт хэрэгжүүлэхэд нэр бүхий 27 иргэнээс 5.8 сая төгрөгийн хамтын төлбөр аваагүй, хамтын төлбөр авдаггүй зөрчил нийтлэг байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3²¹ дахь заалтад нийцэхгүй байна.
- ❖ Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 10 дугаар сарын ЭДМС-ийн санхүүжилтэд түүврийн хяналт хэрэгжүүлэхэд 8 иргэний оношийн бүлэгт хамаарах 2.1 сая төгрөгийн ЭМДС-ийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5²² дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчлөөс үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгосон санхүүжилтээс 192.0 сая төгрөгийг шагнал урамшуулал, бэлэг дурсгал, биеийн тамирын болон нормын хувцас худалдан авах гэх мэт тэвчиж болох зардалд зарцуулсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн үр нөлөөг тодорхой хэмжээгээр бууруулж байна.
2. Хувийн эмнэлгүүд иргэдээс нийтлэг байдлаар төлбөр авч байгаа нь иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангийн үр өгөөжийн талаар сөрөг ойлголт үүсгэж, иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагдах сонирхлыг бууруулах эрсдэл бий болгож байна.
3. Мөрөн сумын хувийн хэвшлийн эмнэлгүүд иргэнд үзүүлсэн нэмэлт үйлчилгээний 56.5 сая төгрөгийн төлбөрийн анхан шатны баримтууд нь хийгдсэн эмчилгээ, үйлчилгээг бүрэн нотолж чадахгүй байна.

Б.2. АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА ХҮН АМЫГ ТОДОРХОЙЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Б.2.1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь лавлагаа шатлалын буюу хавдрын мэс заслын тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлснээр иргэд түргэн шуурхай, цаг алдалгүй тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Хөвсгөл Аймгийн хэмжээнд ЭМД-аас санхүүжилт авч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн ЭМТ, сумын ЭМТ, сувилал, хувийн эмнэлэг зэрэг нийт 39 эрүүл мэндийн байгууллага байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж, үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар дараах ажлыг хийсэн байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 оноос лавлагаа шатлалын буюу хавдрын мэс заслын тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлсэн анхны аймаг болж хавдрын нарийн мэргэжлийн мэс заслын эмч нарыг аймагтаа урин 11 төрлийн 600 хагалгаа хийснээс 43 нь хавдрын хагалгаа хийсэн.

¹⁷ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹⁸ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

¹⁹ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

²⁰ Үйлчлүүлэгчээс эрүүл мэндийн байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах”

²¹ “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.3. даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай, түргэн шуурхай үзүүлэх, даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах;”

²² 16.1.5-д “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;”

2. Гэмтэл согог судлалын төвтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд 2 удаагийн баг ирж түнхний үе бүрэн солих, дунд чөмгөний хагалгаа, шөрмөс залгах зэрэг нийт 35 хагалгаа хийсэн байна.

Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлснээр иргэд Улаанбаатар хот явах зардал гаргахгүй, түргэн шуурхай, цаг алдалгүй тусламж үйлчилгээ авах боломжийг хангаснаар иргэн-даатгуулагчийн хамрагдаж чадахгүй байгаа тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болсон байна.

Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулсан хэдий ч төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: Улаанбаатар хотоос ирсэн эмч нарын байрласан байрны түрээс 3,514.0 мянган төгрөг, орон сууц худалдан авахад 136,384.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Орон нутгийн эмч нарыг нарийн мэргэжлээр сургаж хүний нөөцөө бэлтгэхэд түлхүү анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Аудитын тайлангийн Б.1.1. хэсэгт дэх хэсгийн ЭМД хамрагдалтаас малчин иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан тоон үзүүлэлтийг авч үзэхэд аймгийн хэмжээн дэх нийт малчин иргэдийн дийлэнх хувь буюу 70 орчим хувь нь ЭМД- хамрагдаагүй байна.


Малчин иргэдийн дийлэнх хувь нь албан журмын ЭМД-д хамрагдаагүй байгаа нь малчин иргэд гэнэтийн өвчлөл тохиолдсон үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаас авч чадахгүй байх бодитой эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь албан журмын эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах тухай ойлголт, мэдээлэл дутмаг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2²³-д заасан баг, хорооны Засаг дарга, даатгагчтай байгуулсан гэрээний дагуу даатгуулагчийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

Б.2.2. ЭМД-ын байгууллагаас авсан тусламж үйлчилгээ болон иргэнээс төлбөл зохих төлбөр зэрэг мэдээллийг агуулсан “e-daatgal” аппликэйшны ашиглалт хангалтгүйгээс иргэд шаардлагатай мэдээллээр хангагдаж чадахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10²⁴-д заасан цахим картыг Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид эрүүл мэндийн даатгалд даатгуулсныг гэрчлэх цахим карт олгоно гэж заасан байна.

Тус цахим картаар даатгуулагч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад төлбөр гүйцэтгэх мэдээллийн хэрэгсэл болгон ашиглахаар зохицуулсан боловч дээрх хуулийн заалт одоог болтол хэрэгжээгүй байна. Зураг №4



Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эрүүл мэндийн байгууллага, даатгалын байгууллага болон төрийн байгууллага нь Төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системд тулгуурлан цахим мэдээллийн системийг тус тусад нь хөгжүүлэн ашиглаж байна. Зураглалаас үзэхэд эрүүл мэндийн байгууллагууд нь Ehospital, Ehealth, HICS системийг ашиглаж байгаа бол иргэд, даатгуулагчид

²³ энэ хуулийн 6.1.3-т заасан даатгуулагчийг баг, хорооны Засаг дарга даатгагчтай байгуулсан гэрээний дагуу;

²⁴ “цахим карт” гэж даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас даатгуулагчид олгох цахим гэрчилгээг;

edaatgal аппликэйшн, emongolia, ebarimt зэрэг цахим системийг ашиглан ЭМД-ын шимтгэл төлөх, авсан үйлчилгээгээ хянах боломжтой байна. ЭМД-ын тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн системийн хяналтыг “HICS” цахим систем хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалтай холбоотой ашиглагдаж буй системээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллага болон иргэдэд дараах хүндрэл бэрхшээл учирч байна. **Үүнд:**

1. Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд иргэний мэдээлэл бүртгэгдээгүйгээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллага санхүүжилтээ авч чадахгүй байх. **Тухайлбал:** Аудитаар Энх-Үрс эмнэлгийн 2022 оны 10 дугаар сарын баримт түүвэрлэн үзэхэд дээрх шалтгаанаар 1.2 сая төгрөг хасагдсан байна.
2. ЭМБ-аас тусламж үйлчилгээ авсан иргэний түүхийг хаагаагүйгээс цахим системд битүүмж үүсэх, тус битүүмжийг арилгах хүртэл дараагийн тусламж үйлчилгээг авах боломжгүй болж байна. **Тухайлбал:** Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн бүртгэлийн хэсэгт ажиглалт хийхэд 10 хүн тутмын 3 нь дээрх шалтгаанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хугацааг хойшлуулж чирэгдэл учруулж байна.
3. ЭМД-ын шимтгэлийг нийгмийн даатгалын хэлтсийн орлогын дансаар төвлөрүүлсэн үед шимтгэлийн мэдээлэл 1 хоногоор хоцорч орж байгаа нь иргэдийг чирэгдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг e-barimt системийг ашиглан төлөхөд 20-30 минут зарцуулж байгаа нь иргэнд чирэгдэлгүй хялбар болсон мөн e-mongolia цахим системээс шинжилгээний хариу авах, эмнэлэгт цаг авах зэрэг үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон сайшаалтай тал байгаа хэдий ч даатгуулагч шаардлагатай мэдээллээр хангагдаж чадахгүй байна.

Иргэн Эрүүл мэндийн даатгал төлөлт, Эрүүл мэндийн байгууллагаас авсан тусламж үйлчилгээ, ЭМДС-аас төлсөн дүн зэрэг мэдээлэл бүхий e-daatgal аппликэйшныг ЭМДЕГ-аас 2020 оны 4 дүгээр сараас хөгжүүлэн ашиглаж байгаа хэдий ч бүртгүүлэхэд үүсэж байсан алдаа бүрэн арилаагүй хэвээр байна.

ЭМД-ын байгууллагаас даатгуулагчийг дээрх мэдээллээр бүрэн хангаагаагүйгээс шалтгаалан иргэдэд дараах хүндрэл, зөрүүтэй ойлголтыг үүсгэж байна. **Үүнд:**

- ЭМД төлснөөр ЭМБ-аас бүх тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авна гэх,
- Ямар өртөгтэй тусламж үйлчилгээнд хэдэн төгрөгийн төлөх үүрэгтэй талаарх мэдээлэлгүйн улмаас иргэн хамтын төлбөр төлөхгүй гэх,
- ЭМБ-аас тусламж үйлчилгээ авахдаа иргэнээс төлбөл зохих төлбөрийн талаар мэдээлэлгүйн улмаас илүү, шаардлагагүй төлбөрийг төлсөн гэх.

ЭМД-ын байгууллагаас авсан тусламж үйлчилгээ болон иргэнээс төлбөл зохих төлбөр зэрэг мэдээллийг агуулсан “e-daatgal” аппликэйшны ашиглалт хангалтгүй байна.

Б.2.3. Даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хүртээмжтэй зохион байгуулаагүй байна.

Аймгийн ЭМДХ нь 2022 онд 41 удаагийн сургалт мэдээллийг иргэд, эрүүл мэндийн байгууллага, төр, хувийн хэвшлийн байгууллагуудад телевиз болон цахим, танхимын аргаар орж, фейсбүүк цахим хаягаар 500 гаруй мэдээллийг 5002 хүний хандалттайгаар олон нийтэд түгээж ажилласан байна. Иргэд олон нийтэд дээрх байдлаар мэдээллүүдийг тогтмол хүргэж ажилласан боловч тайлангийн бүлэг Б.2.2-т дурдсанаар иргэд эрүүл мэндийн даатгалын сангийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь дээрх ажлын үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэст хандан иргэдээс 2021, 2022 онд өргөдөл, гомдол гаргаагүй байна.

Б.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ СТАНДАРТ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

Б.3.1. Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүнг орон нутагт дүгнэх боломжгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтсийн чиг үүрэг”-ийн 5.1²⁵-д зааснаар ЭМДЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газар нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тул орон нутагт бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Б.3.2. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд холбогдох стандарт, журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.

ЭМДХ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар тогтоолоор эрүүл мэндийн байгууллагаас гэрээний дагуу худалдан авах тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх “Чанар, төлбөрийн хяналтын журам”-д заасан нэр төрлөөр хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна. Үүнд:

Хүснэгт №10

№	Хяналтын төрөл	Хяналт хэрэгжүүлсэн байдал /тоол/	
		2021 он	2022 он
1	Нэхэмжлэлийн хяналт /цахим, нарийвчилсан, нэмэлт/	Сар бүр	Сар бүр
2	Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт	Ковид цар тахлаас шалтгаалан тул газар дээр ажиллаагүй	3 удаа / хувийн эмнэлэг 9, сумын эрүүл мэндийн төв 6, эмийн сан 16/
3	Чанарын үнэлгээ	99	71
4	Гэрээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх	79	28

Хүснэгтээс харахад нэхэмжлэлийн хяналтыг нийт нэхэмжилсэн дүнгийн 15-20 хувьд түүврээр сар бүр, газар дээр нь очиж хийх хяналтыг 2021 онд нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжүүлээгүй, 2022 онд 3 удаа нийт 31 байгууллагад хяналтыг хэрэгжүүлсэн байна. Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх хяналтыг 2021 онд 60 эмийн сангаас 51 эмийн сан, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 28 байгууллагын гэрээг дүгнэсэн байна. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын гэрээг ЭМДЕГ-ын худалдан авалт гэрээлэлтийн газар материалыг цахимаар татан авч гэрээ дүгнэсэн байна.

Дээрх хяналт шалгалтаар дараах зөрчил гарч холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж 2021 онд 3,382.4 сая төгрөг, 2022 онд 2,498.5 сая төгрөгийн хасалт хийж санхүүжилтийг олгосон байна. /Хасалтын дэлгэрэнгүйг хавсралт 4-р харуулав./
- АНЭ-ийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцсон байна. Нийт судалгаад хамрагдсан иргэдийн 83% сайн, 15% дунд, 2% муу үнэлгээ өгсөн байна.
- 2020, 2021 оны нэхэмжлэлээс түүвэрлэн хянахад 87 даатгуулагчийн өдрийн эмчилгээний түүх хоосон, үзлэг тэмдэглэлгүй, тухайн хугацааны эмийн захиалгыг тулган шалгахад эмийн захиалга зарлага байхгүй зөрчилд 6.7 сая төгрөгийн акт тогтоохоор, тайлангийн хамт дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газарт хүргүүлсэн байна.
- ЭМГ-ын дарга, ЭМДХ-ийн даргын хамтарсан удирдамж баталж эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран хяналтаар гэрээний хэрэгжилтийг шалгаж гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж буй “Эм увдис” эмийн сангийн гэрээг цуцлуулахаар хүсэлт хүргүүлсэн байна.

²⁵ Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: “5.1 Хууль, тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах;”

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс түүвэр хяналт хийхэд дараах нийтлэг хасагдлын шалтгаануудтай байна. Үүнд:

1. Эмнэл зүйн шалгуур хангаагүй,
2. Өвчний оношны хамааралтай бүлгийг буруу шивж илгээсэн,
3. Эмчилгээ, үйлчилгээг давхардуулан нэхэмжилсэн,
4. Өвчний түүхэнд байх ёстой мэдээллүүдийг дутуу бичсэн,
5. Эмч хөнгөлөлттэй эмийн жор бичихдээ оношны бүлэгт хамааралгүй эм бичсэн,
6. Цахимаар бодит цагийн горимоор мэдээллийг шивээгүй,
7. Ажлын цагт багтаан илгээгээгүй,
8. Гэрээнд заагдаагүй оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэл илгээсэн.

Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтаар шалгуур хангахгүй хасагдсан тохиолдлын оношийн хамааралтай бүлэг нь Эх олонлогт тооцогдон системээр хасагддаг байна. 2021 онд ЭМДҮЗ-ийн 28 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын анхан шатны баримтуудыг 100 хувь татан авч хяналтыг хэрэгжүүлдэг байсан байна. Тус оны 08 сараас цахим системээр түүвэр унаж эхэлсэн байна. Лавлагаа шатлалын эмнэлгийн 11 байгууллагаас ирүүлсэн 167,900 даатгуулагчийн 14,641.8 сая төгрөгийн нэхэмжлэлээс 3,226 даатгуулагчийн 354.8 сая төгрөгийн тусламж үйлчилгээний зардал эмнэл зүйн шалгуур хангаагүй хасагдсан байна..

2022 онд 169,726 хүний 19,719.3 сая төгрөгийн нэхэмжлэлээс 5,254 түүврээс эмнэл зүйн хяналтаар 2274 хүний 578.5 сая төгрөг, ерөнхий шалгуураар 907 хүний 51.0 сая төгрөгийн тусламж үйлчилгээний зардал хасагдсан байна.

Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж, үйлчилгээ болон эмийн сангийн даатгуулагчдад олгосон эмийн зардлыг 100 хувь хянаж байгаа бол сумын эрүүл мэндийн төвийн хэвтүүлэн эмчлүүлсэн тусламж үйлчилгээг зорилтот түүврээр хянаж ажилласан байна

Б.3.3. ЭМДЕГ нь 2022 онд чанарын үнэлгээ гүйцэтгэсэн боловч үр дүнг олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар “Хяналтын журам батлах тухай” тогтоолоор ЭМДЕГ-ын хэрэгжүүлэх дараах хяналт шалгалтыг тогтоож өгсөн байна. Үүнд:

- Эмнэл зүйн аудитыг ЭМДЕГ-ын хяналтын зохицуулалтын чанарын үнэлгээний хэлтэс зохион байгуулах бөгөөд хууль шүүхийн маргаан, иргэн-даатгуулагчийн зүгээс эрүүл мэнд амь нас хохироосон гомдол, эмнэлгийн сөрөг үр дагавартай тохиолдлууд дээр сонгон шалгаруулалтын үр дүнд сонгогдсон шинжээч эмч гүйцэтгэх хяналт
- Жил бүр зонхилон тохиолддог тодорхой тооны тусламж үйлчилгээг сонгон авч чанарын үнэлгээ хийх.

Жил бүр зонхилон тохиолдсон тусламж үйлчилгээнд чанарын үнэлгээ гүйцэтгэх нь тухайн бүс нутагт тохиолдож буй өвчлөл түүнд үзүүлэх тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагад гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой хариу арга хэмжээг шуурхай шийдвэрлэх ач холбогдолтой байна.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/121 дугаартай тушаалаар баталсан удирдамжид чанарын үнэлгээ, эмнэл зүйн аудитын талаар тусгасан боловч үр дүнг олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Аудитаар нийт 6,144.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 754.5 сая төгрөгийн 6 албан шаардлага, 5,389.7 сая төгрөгийн 14 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын нэгдсэн тайланд тусгуулах 7 саналыг тайлангаар хүргүүлж ажиллалаа.

АУДИТЫН НЭГДСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:

1. Эрүүл мэндийн даатгалын салбарт мөрдөгдөж буй эрх зүйн баримт, бичгийн тогтвортой байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмжийг эрүүл мэндийн даатгалын дээд байгууллагуудад хүргүүлэх,
2. Орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн бие даасан байдлыг хангах асуудлыг дэвшүүлэх,
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5²⁶-д заагдсан иргэнээс шууд хандаж тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх
4. Сонгон шалгаруулалтын тусгай шаардлагыг орон нутгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хүрэлцээ, хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эмнэлгүүдийн эмчийн бодит чадамж, ажлын туршлага, төрийн эмнэлгийн ачаалал зэргийг харгалзан боловсруулах,
5. Цахим сонгон шалгаруулалтад илгээхгүй байж болох мэдээллийг оруулаагүй тохиолдолд материал хүлээн авдаггүй программын хүндрэлийг арилгах,
6. Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг дур мэдэн, хяналтгүй зарцуулж байгаа нь нөхөрлөлийн хэлбэрт шилжсэнтэй холбоотой байгаа тул энэ талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т зааснаар ЭМДС-ийн орлого бүрдүүлэх ажлыг Нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэж байгаа нь Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь зөвхөн гаргах зардлаа тооцдог орлого, зарлагын харьцаагаа хангаж чадахгүй байх нөхцөлийг үүсгэж байгаа тул энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

зэрэг саналуудыг холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн, шийдвэрлүүлэх саналтай байна.

²⁶ 7.5.Иргэн дараахь тохиолдолд эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвд шууд хандаж болно:

7.5.1.осол, гэмтэлд өртсөн, амь тэнссэн, эмнэлгийн яаралтай тусламж авах хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн;

7.5.2.төрөх үеийн эх барихын яаралтай тусламж, үйлчилгээ авах;

7.5.3.шүд, эрүү, нүүр амны өвчин эмгэгийн улмаас тусламж, үйлчилгээ авах.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтыг төрөөс бодлогоор хэрэгжүүлж, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгал төлсөн иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана байгаагаас үл шалтгаалан төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах боломжтой болж бодит үр дүн гарсан байна.
2. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хууль, тогтоомж, дүрэм, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт 55 хувьтай байна.
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлыг төлөвлөхдөө орон нутгийн саналыг авахгүйгээр төлөвлөж баталснаар орлого тасарсан, хамрагдалтын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс шалтгаангүйгээр бууруулж баталсан, зөвхөн малчин иргэдийн хамрагдалтыг түүвэрлэн хянахад төлөвлөсөн хэмжээнээс 67,3-71.2 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулж чадаагүй байгаа зэрэг нь сангийн хөрөнгийн төлөвлөлт бодит тоо судалгаанд үндэслээгүй байгааг харуулж байна.
4. Аймгийн ЭМДХ- нь дутуу орон тоог бүрдүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, чанар төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шаардлага хангасан хүний нөөц дутмаг байгаа зэргээс шалтгаалан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн нэхэмжлэлд хангалттай хяналтыг хэрэгжүүлэх боломж бүрдэхгүй байна.
5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг журам зааврын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажилласан боловч, гэрээний хэрэгжилтийг бүрэн дүгнээгүй байна.
6. Эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлийг хянахад зарим эрүүл мэндийн байгууллагууд нь бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, шагнал урамшуулал олгосон, тоног төхөөрөмж, эмийг тендергүйгээр шууд худалдан авсан, зэрэг нь сангийн хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль журмыг мөрдөхгүй байгааг харуулж байна.
7. Өрхийн эрүүл мэндийн төв нь хөрөнгийн зарцуулалт, бүтэц орон тоо, цалин тогтоолт зэрэг асуудлыг нөхөрлөлийн гишүүдийн шийдвэрээр, холбогдох хууль журамд нийцэхгүй шийдвэр гаргаж, хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулж байгаа нь нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой байна.
8. ЭМД-ын үйл ажиллагаатай холбоотой цахим системүүдийг ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдын мэдлэг дутмаг, тусламж үйлчилгээ болон иргэнээс төлбөл зохих төлбөр зэрэг мэдээллийг агуулсан “e-daatgal” аппликэйшныг даатгуулагч иргэд ашиглаж мэдэхгүй байгаагаас иргэдэд багагүй чирэгдэл учруулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Ж.Түвшинтөгсөд:

1. Хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах.
2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан орон тоог бүрдүүлж ажиллах талаар арга хэмжээ авч авах.
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, баталсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах.
4. Эрүүл мэндийн даатгалын талаарх хууль тогтоомж, төрөөс хэрэгжүүлсэн бодлогыг олон нийтэд сурталчлан таниулж, E-daatgal аппликэйшны хэрэглээг нэмэгдүүлэх.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Д.Түвшинбаярт:

5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах
6. Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Л.Юмжирдуламд:

7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, баталсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Г.Оюунжаргалд:

8. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах
9. Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн иргэдээс гэрээнд заасан иргэний хариуцах төлбөрийг тогтоосон хэмжээгээр жигд авч ажиллах

Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт:

10. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах
11. Хөрөнгө захиран зарцуулахдаа хууль, эрх зүйн үндэслэл бүхий санхүүгийн анхан шатны нотлох баримтыг бүрэн бүрдүүлж ажиллах.
12. Иргэдэд 13а маягтыг олгохдоо төрийн болон хувийн гэж ялгаварлахгүйгээр олгож хэвших

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн дарга нарт:

13. Гэрээнд зааснаас бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу үзүүлж, нэмэлт төлбөр авахдаа холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлж ажиллах
14. Иргэнээс авч байгаа төлбөрийг хэн нэгэн албан хаагчийн хувийн дансаар хүлээн авсан зөрчлийг таслан зогсоож, байгууллагын дансанд төвлөрүүлж, тайлагнаж ажиллах

Зөрчлийн жагсаалт:

/Сая.төгрөг/


№	Илэрсэн зөрчлийн	Дүн	Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЭМДХ нь хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-					1	-
2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022-01-24-ний А/10 дугаар тушаалаар баталсан орон тоог бүрдүүлж ажиллаагүй байна.	-					1	-
3	2022 оны орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлэн баталсан бөгөөд 3,968.2 сая төгрөгөөр орлого тасарсан	3,968.2					2	3,968.2
4	ЭМД-ын үйл ажиллагаатай холбоотой цахим системүүдийг ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдын мэдлэг дутмаг, тусламж үйлчилгээ болон иргэнээс төлбөл зохих төлбөр зэрэг мэдээллийг агуулсан “e-daatgal” аппликэйшнийг даатгуулагч иргэд ашиглаж мэдэхгүй байгаагаас иргэдэд чирэгдэл учруулж байна	-					1	-
5	Сумын эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тайланг 679.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	679.2			1	679.2		
6	Хувийн эрүүл мэндийн байгууллагууд гэрээнд зааснаас бусад төлбөртэй үйлчилгээ үзүүлэхдээ нэмэлт төлбөрийг нийтлэг байдлаар авсан, холбогдох анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.	56.5					1	56.5
7	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлоогүй байна.						1	-
8	Өрх, сум, тосгоны ЭМТ-ийн 2022 оны гуравласан гэрээ бүрэн хэрэгжээгүй байна.						1	-
9	Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулсан, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллаагүй байна.	1,312.7			4	35.1	2	1,277.6
10	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь хувийн эмнэлэгт хэвтэх иргэдэд 13а маягтыг хүн бүрд олгодоггүйгээс иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт эдэлж чадахгүй, эсвэл хувийн эмнэлэг санхүүжилтээ авч чадахгүй байх чирэгдлийг үүсгэж байна.						1	-
11	Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй иргэдээс гэрээнд заасан иргэний хариуцах төлбөрийг жигд авч ажиллаагүй байна.						1	-
12	Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод ажилласан нийт албан хаагчдад 87.4 сая төгрөгийн урамшуулал олгохдоо гаргасан тушаал шийдвэр нь хууль эрх зүйн үндэслэл хангалтгүй, санхүүгийн анхан шатны нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.	87.4					1	87.4
13	Нэмэлт үйлчилгээ үзүүлж иргэдээс төлбөр авахдаа байгууллагын дансаар дамжуулалгүй хувийн харилцах дансаар авсан байна.						1	-
14	ӨЭМТ-ийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 40.2 сая төгрөг зарцуулсан байна.	40.2			1	40.2		
НИЙТ ДҮН		6,144.2			6	754.5	14	5,389.7

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

№	Холбогдох байгууллагын саналууд	Тайлбар
	 ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС 67120, Хөвсгөл аймаг, Мөрөн сум Утас/Факс: (976) 7038-7039, И-мэйл: khuvsgul@emd.gov.mn Вэбсайт: www.emd.gov.mn 2023.05.19 № 31/92 танай _____ -ны № _____ -т Санал хүргүүлэх тухай Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлд дурдагдсан зарим асуудлуудад дараах тайлбар хүсэлтийг хүргүүлж байгааг хүлээн авч тайлангийн төсөлд өөрчилж өгнө үү. Үүнд: Нэг.Эрүүл мэндийн даатгалын хэлтэс хууль, тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хэдийгээр хүний нөөц дутагдалтай боловч тайлант онуудад албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг сайн маш сайн үнэлгээтэй дүгнэгдсэн. Газар дээрх хяналтыг он онд төлөвлөгдсөн тоо байхгүй бөгөөд цар тахлын нөхцөл байдалтай холбоотой байгаа. Хоёр.Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж төлбөрийг олгосон боловч сумын эрүүл мэндийн төвд нэг иргэнээр тооцож олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна гэснийг Аймгийн ЭМГ-ын эдийн засагч Х.Амаржаргал, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн Г.Аззаяа нар ЭМДЕГ-ын БТГ, СБХ-н холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдон тулгаж 2022 оны 1-2 сард улсын төсвийн санхүүжилт ЭМДЕГ-аар дамжин орсонтой холбоотойгоор зөрүүтэй байсныг тогтоож тааруулсан тул төслөөс хасаж өгнө үү. Гүрвэ.Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажил хангалтгүй байна. Байгууллагын үйл ажиллагаа, даатгуулагчийн эрх болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаарх нэгдсэн мэдээ, мэдээллийг сургалт сурталчилгааны бүхий л төрлийг ашиглан бэлтгэж, олон нийтэд түгээж, мэдээллийн ил тод байдлыг хангуулах чиг үүргийн хүрээнд Албан ёсны цахим хаягуудаар нийт 827 контент бэлтгэн, түгээсэн, үүнээс постер 313, хөдөлгөөнт постер 55, видео бичлэг 43, цаг үе үйл явдлын мэдээ мэдээлэл 72-г тус тус боловсруулж түгээсэн. Хандалтын тоо 8 сая 200 мянган хүнд хүрсэн. Хандалт нэмэгдсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 200 мянган хүнд хүрч, 14,602 удаа хуваалцсан байгаа тул дээрх асуудлыг өөрчилж өгнө үү. Дөрөв.Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт 50 хувь, Аймгийн Эрүүл мэндийн хэлтсийн даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 21 арга хэмжээг 97.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан ба ЭМДЕГ-ын даргаар дүгнүүлж баталгаажуулаагүй зэргээс үзэхэд Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хууль, тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. 2021, 2022 оны Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргаар батлуулан биелэлтийг тайлагнан дүгнүүлсэн үнэлгээний хуудсыг хүргүүлсэн байгаа тул эргэж харна уу. /дахин сканердаж хүргүүлэв/	1. Саналыг хүлээж авах боломжгүй 2. Саналыг хүлээж авах боломжгүй 3. Саналыг хүлээж авах боломжгүй 4. Саналыг хүлээж авч тайланд өөрчлөлт оруулсан

	Тав. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дутуу орон тоог бүрдүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, чанар төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шаардлага хангасан хүний нөөц дутмаг байна. Зургаа Б.3.2. Анхан шат болон эмийн сангийн нэхэмжлэлийг өндөр дүнтэй нэхэмжлэлүүдээс цахимаар эмнэл зүйн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үндсэн тусламж үйлчилгээ тогтмол тарифтай, эмийн сангийн даатгуулагчид олгосон эмийн зардал түүвэрлэгдэдэггүй 100% хянагддаг бөгөөд зөвхөн сумын эрүүл мэндийн төвийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ нь зорилтот түүврээр түүвэрлэгдэн хянагддаг. Долоо. Б.3.3. ЭМДЕГ-аас Хөвсгөл аймагт 2021, 2022 онд зонхилон тохиолдсон тусламж үйлчилгээнээс сонгон авч чанарын үнэлгээ хийгээгүй байна. ЭМДЕГ-ын 2022 оны 10 дугаар сарын 14 -ний 01/4863 дугаар албан тоотоор 2021-2022 оны Зонхилон тохиолдох тодорхой тооны тусламж үйлчилгээг сонгон жагсаалт ирүүлж өвчний түүхийг татан авч эмнэл зүйн аудит хийсэн бөгөөд улс даяар хийгдэж байгаа, бүрэн дуусаагүй хэрэгжих шатандаа байгаа тул уг дүгнэлтийг хасаж өгнө үү ЭМДЕГ-ын Тамгын газраас Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэх зарыг Төрийн албаны болон ЭМЯ-ны салбар зөвлөлийн сайтад байршуулсан бөгөөд тухайн ажлын байранд санал ирүүлсэн албан хаагч байхгүй байгаа нь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн эрхлэх хүрээний асуудалтай холбоогүй тул эргэж харна уу. Аудитын дүгнэлтийн 2 .Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт 50 хувь, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргаар дүгнүүлж баталгаажуулаагүй зэргээс үзэхэд Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хууль, тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж дүгнэлээ 2022 оны Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргаар батлуулан биелэлтийг тайлагнан дүгнүүлсэн үнэлгээний хуудсыг хүргүүлсэн байгаа тул дээрх дүгнэлтийг хасаж өгнө үү. /дахин сканердаж хүргүүлэв/ ХЭЛТСИЙН ДАРГА  Ж ТҮВШИНТӨГС	5. Саналыг хүлээж авч тайланд өөрчлөлт оруулсан 6. Саналыг хүлээж авч тайланд өөрчлөлт оруулсан 7. Саналыг хүлээж авч тайланд өөрчлөлт оруулсан Саналыг хүлээж авч тайланд өөрчлөлт оруулсан
--	---	--

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд:

1	 Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газраас нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Гэрээнд зааснаас бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу үзүүлж, нэмэлт төлбөр авахдаа холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлж ажиллана. Иргэнээс авах төлбөрийг байгууллагын дансанд төвлөрүүлж үнэн зөв тайлагнаж ажиллана. Дээрх зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана. ЗАХИРАЛ Ш.ШАРАВДОРЖ	Тайлангийн төсөлд санал нэг байна.
2	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ Хөвсгөл аймгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууны дунд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын төслийн тайлантай танилцлаа. Тайланд тусгасан зүйлд нэмэлт тайлбар байхгүй. ЗАХИРАЛ П.ЭРДЭНЭЧУЛУУН	Тайлангийн төсөлд санал нэг байна.

3	ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Хөвсгөл Цээнэ эмнэлэг нь “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав. Хариу тайлбаргүй болно.	Тайлангийн төсөлд санал нэг байна.
4	ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ Санал хүргүүлэх тухай “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа Манай байгууллагын хувьд ЭМДЕГ-тай гэрээлээгүй тусламж үйлчилгээ үзүүлэхдээ тухайн өвчтөний хүсэлтийг харгалзан төлбөрт үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн үндэслэлүүдийг үндэслэн монголын бусад хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй харьцуулбал хамгийн бага тарифаар тооцон нөхөн сэргээх, цахилгаан эмчилгээ, мөн тав тухын нэмэгдлийг тооцон авч ажиллаж байгаа. Энэхүү хяналтаар бид анхан шатны маягтдаа дутуу тусгасан, мөн хувийн дансаар төлбөр авч байгаа зэрэг зөрчил гаргаж байгаагаа хүлээн зөвшөөрч засаж залруулж ажиллаж эхэлсэн. 2020 оноос хэрэгжиж буй шинэ татварын хуулиар эрүүл мэндийн үйл ажиллагаа /клиник, амбулатори/ эрхэлж буй ААН нь ААН-н орлогын албан татварын хуулийн 21-1-9-д зааснаар /Эрүүл мэндийн тухай хуулийн 15-1-4-т заасан байгууллагын үйл ажиллагааны орлого нь ААН-н орлогын албан татвараас чөлөөлөгдөж байгаа учраас орлогоо нуун дарагдуулах үйлдэл хийдэггүй. Хувийн дансаар төлбөр авсан шалтгаан нь: Эмнэлгийн касс няравт компаний дансны мэдээлэл тэр дороо очдоггүй, олон хүний мобайл гүйлгээ үнэн зөв орсон эсэхийг тэр дор нь шалгахад хүндрэл учирдаг, ба татварын хяналтаар тухайн компаний данс, захиралын хувийн дансыг нэг бүрчлэн шалгадаг учраас бид орлогоо нуун дарагдуулах боломжгүй юм. Манай байгууллага нь 2021,2022 оны санхүүгийн тайландаа бүх орлогоо тусгаж тайлагнаж, 2022 ондоо Хөвсгөл аймгийн шилдэг татвар төлөгч байгууллагаар шалгарсан. Иймд аудитын тайлангийн төсөлд татвар ноогдох орлогыг нуун дарагдуулсан байж болзошгүй үйлдэл гэж үзэн дараагийн шатны байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв гэж уг төсөлд заасан байгааг өөрчилж өгнө үү. ХҮСЭЛТ ИЛГЭЭСЭН “ОЮУ-УНДРАА” ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ <i>Р.НАРАНТУЯА</i>	Саналыг хүлээн авч тайланд тусгав.

5	Хөвсгөл аймгийн Аудитын хэлтэст Аймгийн Аудитын хэлтсээс ирүүлсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Манай эмнэлэг нь ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан журмын дагуу ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэйгээр үзүүлэхээс гадна гэрээнд заагаагүй, тус эмнэлэг дээр хийгддэг сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлдэг. Үүнд тухайн сэргээн засах тусламж, үйлчилгээний төрөл болон хоногийн төлбөрийн хэмжээг холбогдох эрх зүйн актын дагуу тогтоож, эмнэлгийн даргын тушаалаар баталгаажуулан хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд санал болгодог ба үйлчлүүлэгч өөрөө хүссэн тохиолдолд энэхүү үйлчилгээг баталсан тарифийн дагуу авч үйлчилгээний төлбөр төлдөг. Энэ төлбөрийг авахдаа анхан шатны маягтыг дутуу бүрдүүлсэн, хувийн дансаар төлбөр авсан зөрчил байгаа нь энэхүү хяналтаар илэрснийг хүлээн зөвшөөрч, цаашид энэ зөрчлийг давтахгүйгээр засч ажиллаж байна. Ирүүлсэн тайлангийн төсөлд байгаа дүгнэлтэнд оруулах доорх тайлбар, саналыг хүлээн авч шийдвэрийг өөрчилж өгөхийг хүсч байна. Үүнд: 2020 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 21.1.9 дүгээр заалтад заасны дагуу 14 төрлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны орлого аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөж байгаа учраас орлогоо нуун дарагдуулах үйлдэл хийдэггүй. - Үйлчилгээний төлбөрийг хувийн дансаар дамжуулан авсны учир нь үйлчлүүлэгч компанийн дансанд орлого шилжүүлсэн гэхэд компанийн дансны гүйлгээний мэдээлэл (мессеж) тухайн үедээ ирдэггүй учраас гүйлгээ хийгдсэн эсэхийг хянах боломжгүй байдаг. Энэхүү байдлыг харгалзан үзэж аудитын тайлангийн төсөлд байгаа “...татвар ноогдох орлогыг нуун дарагдуулсан байж болзошгүй үйлдэл гэж үзэн дараагийн шатны байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.” Гэж заасныг өөрчилж өгнө үү хэмээн хүсэлт хүргүүлж байна. Хүндэтгэсэн: “Хүмүүн” эмнэлгийн дарга Ө. Отгонцэрэн 2023-он 05-сарын -19	Саналыг хүлээн авч тайланд тусгав.
6	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨНХТУЛУГУУР ХХК Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 4780 2023-05-19 № 17 танай -ны № -т Хүсэлт хүргүүлэх нь: Төрийн аудитын газраас нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн төсөлтэй танилцлаа. Манай эмнэлэг нь ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан журмын дагуу ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэйгээр үзүүлэхээс гадна гэрээнд заагаагүй, тус эмнэлэг дээр хийгддэг сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлдэг. Үүнд тухайн сэргээн засах тусламж, үйлчилгээний төрөл болон хоногийн төлбөрийн хэмжээг холбогдох эрх зүйн актын дагуу тогтоож, захирлын тушаалаар баталгаажуулан хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд санал болгодог ба үйлчлүүлэгч өөрөө хүссэн тохиолдолд энэхүү үйлчилгээг баталсан тарифийн дагуу авч үйлчилгээний төлбөр төлдөг. 2020 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 21.1.9 дүгээр заалт “Эрүүл мэндийн тухай” хуулийн 15.1.4-д тус тус заасны дагуу 2021, 2022 оны тайлангаа санхүүгийн тайландаа бүрэн тусгасан байгууллагын үйл ажиллагааны орлого нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөж байгаа учраас орлогоо нуун дарагдуулах үйлдэл хийдэггүй. - Үйлчилгээний төлбөрийг хувийн дансаар дамжуулан авсны учир нь үйлчлүүлэгч компанийн дансанд орлого шилжүүлсэн гэхэд компанийн дансны гүйлгээний мэдээлэл (мессеж) тухайн үедээ ирдэггүй учраас гүйлгээ хийгдсэн эсэхийг хянах боломжгүй байдаг. Тухайн орсон орлогыг хувийн хэрэгцээнд ашигладаггүй. Энэхүү байдлыг харгалзан үзэж аудитын тайлангийн төсөлд байгаа “...татвар ноогдох орлогыг нуун дарагдуулсан байж болзошгүй үйлдэл гэж үзэн дараагийн шатны байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.” гэж заасныг өөрчилж өгнө үү хэмээн хүсэлт хүргүүлж байна. ЗАХИРАЛ  Ц.НЯМАА 	Саналыг хүлээн авч тайланд тусгав.

	Өрхийн эрүүл мэндийн төвүүд	
7	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ЭНХ-ҮЙЛС” ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3464 Цахим шуудан: Enkhulb.emt@gmail.com 2023.05.19 № 15 танай _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1. Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2-д заасан Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог бусад хууль, дүрэм журамд тусгаж бүх шатанд нэгдсэн нэг ойлголттой болох 2. ЭМДЕГазраас ӨЭМТөвүүдэд олгож буй санхүүжилтийг цаг тухай бүр олгож байх /он дамнуулахгүй байх/ 3. Нийгмийн эрүүл мэндийн зардлыг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсөвт нэмэлтээр суулгаж өгөх ДАРГА <i>Б. Золзаяа</i> Б.ЗОЛЗАЯА D:\HP\alban bichig\ 2023-A5.docx	
8	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ДЭЛГЭЭРМӨРӨН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ 67127, Хөвсгөл аймаг, Мөрөн сум Утас: 70382162 2023.05.19 № 02 танай _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1. Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2-д заасан Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог бусад хууль, дүрэм журамд тусгаж бүх шатанд нэгдсэн нэг ойлголттой болох 2. ЭМДЕГазраас ӨЭМТөвүүдэд олгож буй санхүүжилтийг цаг тухай бүр олгож байх /он дамнуулахгүй байх/ 3. Нийгмийн эрүүл мэндийн зардлыг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсөвт нэмэлтээр суулгаж өгөх. ДАРГА <i>Б. Пүрэвсүрэн</i> Б.ПҮРЭВСҮРЭН D:\HP\alban bichig\ 2023-A5.docx	

9	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ДАЛАЙН-ЭЛБЭРЭЛТ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038-8003 Цахим шуудан: dalainelberelt.emt@gmail.com 2023-05-19 № 42 Танай _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1. Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2-д заасан Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог бусад хууль, дүрэм журамд тусгаж бүх шатанд нэгдсэн нэг ойлголттой болох 2. ЭМДЕГазраас ӨЭМТөвүүдэд олгож буй санхүүжлтийг цаг тухай бүр олгож байх / он дамнуулахгүй байх/ 3. Нийгмийн эрүүл мэндийн зардлыг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсөвт нэмэлтээр суулгаж өгөх ДАРГА  Ц.БУЯННЭМЭХ	
10	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨВСГӨЛ ЭНЭРЭЛ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3487 2023.05.19 № 25 Танай _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1. Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2-д заасан Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог бусад хууль, дүрэм журамд тусгаж бүх шатанд нэгдсэн нэг ойлголттой болох 2. ЭМДЕГазраас ӨЭМТөвүүдэд олгож буй санхүүжлтийг цаг тухай бүр олгож байх / он дамнуулахгүй байх/ 3. Нийгмийн эрүүл мэндийн зардлыг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсөвт нэмэлтээр суулгаж өгөх ДАРГА  Ж.АЛТАНЦЭЦЭГ	

11	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨВСГӨЛ ГУРВАН ГАЛ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3417 <u>2023.05.19</u> № <u>10</u> таний <u>2023.05.19</u> -ны № <u>01/599</u> -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Төрийн аудитын газраас нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж байна. Цаашид иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, анхан шатны тусламжид зарцуулах санхүүжилтийг олон улсын түвшинд хүргэх зорилгоор: 1. 1 иргэнээр тооцсон зардлыг инфляцын түвшинтэй уялдуулж жил бүр нэмэгдүүлэх 2. Өрхийн эрүүл мэндийн төвд нийгмийн эрүүл мэндийн зардлыг тусгаж өгөх 3. Иргэний эмнэлэг, эмчээ сонгох эрхийг хангахын тулд үйлчлүүлсэн эмнэлэгт нь гүйцэтгэлийн санхүүжилтийг олгох 4. Түр оршин суугч, ЭМД төлж чадахгүй зэрэг зорилтот бүлгийн авсан тусламж үйлчилгээг шийдвэрлэх 5. ЭМДЕГ үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлыг хугацаанд нь шилжүүлдэг болох зэрэг саналыг хүргүүлж байна. ДАРГА - <u>2.1.1.1</u> Ж.СҮНЖИДМАА 171120 Doc: Alban bichig A-5	
12	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ Нэгдсэн эмнэлгийн захиргааны байр, Уран дөш баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 75750011, Факс: 70382562 Цахим шуудан: negdsenemneleg@khs.gov.mn Цахим хуудас: moh.khs.gov.mn <u>2023.05.20</u> № <u>400</u> таний _____ -ны № _____ -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. ЗАХИРАЛ <u>М.ОЮУНЖАРГАЛ</u> 	Тайлангийн төсөлд санал нэг байна.

Хавсралт №1

/сая.төг/

№	Үзүүлэлт	2021 он					2022 он				
		Хамрагдалтын		Орлогын			Хамрагдалтын		Орлогын		
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Хувь	Төл	Гүйц	Төл	Гүйц	Хувь
Ажил олгогч болон даатгуулагчийн төлөх шимтгэл											
1	Төсөвт болон ААН байгууллагын ажилтан	-	9,147	4,699.5	4,878.6	103.8	-	12,952	9,863.1	5,884.9	59.6
Эрүүл мэндийн даатгалаа өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэл											
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	8,400	2,977	858.5	766.4	89.2	7,560	3,016	1,006.8	1,016.7	100.9
3	Малчин	18,000	5,207				14,400	4,703			
4	Оюутан, суралцагч	1,700	428				2,500	477			
Нийт дүн		28,100	8,612	858.5	766.4	89.2	24,460	8,196	1,006.8	1,016.7	100.9
Төр даатгалыг нь хариуцан төлөх даатгуулагчийн шимтгэл											
5	Төр даатгалыг нь хариуцан төлөх даатгуулагчийн шимтгэл	-	104,611	-	-	-	-	101,275	-	-	-
	Бусад	-	-	4.7	-	-	-	-	-	-	-
Нийт дүн		28,100	122,370	5,562.7	5,645.1	101.5	24,460	122,423	10,869.9	6,901.6	63.5

Хавсралт №2

/сая.төг/

Үзүүлэлт	2021 он			2022 он		
	Байгууллагын тоо	Даатгуулагчийн тоо	Цалингийн сан	Байгууллагын тоо	Даатгуулагчийн тоо	Цалингийн сан
НДХ-ийн гүйцэтгэлээр	1,102	22,693	165,076.1	1,143	24,055	187,203.0
Татварын цалин хөлсний тайлангаар		59,486	327,615.2		61,972	376,538.2
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл /Аудитаар тооцсон/			6,603.0			7,488.1
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл /ЭМДЕГ-аас төлөвлөсөн/			5,218.9			5,948.0
Зөрүү дүн			1,384.1			1,540.1

Хавсралт №3

/сая.төг/

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД 2021 ОНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ

д/д	Эрүүл мэндийн байгууллага	Олгохоор тооцсон		Нийт
		2021 он	2022 он	
1	Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг	12,493.4	13,367.1	25,860.5
2	ГУАМӨРӨН ХХК-ийн Гуа мөрөн эмнэлэг	435.5	337.7	773.3
3	МӨНХТУЛГУУР ХХК-ийн Мөнхтулгуур эмнэлэг	645.3	448.8	1,094.1
4	ОТОС НАМНАН ХХК Отос намнан эмнэлэг	499.2	588.3	1,087.5
5	Хөвсгөл - Барнууд ХХК Жаргалан эмнэлэг	620.7	490.5	1,111.2
6	Хөвсгөл "Оюу-Ундраа" ХХК Оюу-Ундраа эмнэлэг	887.5	1,012.3	1,899.8
7	ХӨВСГӨЛ РЕНЧИН ЖУГНАЙ ХХК Ренчинжугнай эмнэлэг	503.6	413.4	917.0
8	Хөвсгөл хүмүүн ХХК Хүмүүн эмнэлэг	509.9	387.9	897.9
9	ХӨВСГӨЛ ЦЭЭНЭ ХХК Цээнэ эмнэлэг	662.2	645.9	1,308.1
10	Энх-Үрс эмнэлэг	410.6	436.0	846.6
11	Гурван гал ӨЭМТ	150.9	303.1	454.1
12	Далайн элбэрэлт ӨЭМТ	381.3	713.6	1,094.9
13	Дэлгэрмөрөн ӨЭМТ	196.9	409.3	606.2
14	Энх-Үйлс ӨЭМТ	160.4	319.5	479.8
15	Энэрэл ӨЭМТ	294.0	589.0	883.0
16	ГАЛТ ХАЛУУН РАШААН ХХК Галтын халуун ус	433.6	783.1	1,216.7
17	Алаг-Эрдэнэ СЭМТ	247.7	563.7	811.4
18	Арбулаг СЭМТ	138.3	635.4	773.7
19	Рашаант СЭМТ	232.9	619.9	852.8
20	Тариалан СЭМТ	702.1	1,028.8	1,730.9
21	Баянзүрх СЭМТ	223.5	672.1	895.6
22	Бүрэнтогтох СЭМТ	192.7	603.5	796.2
23	Галт СЭМТ	210.7	817.4	1,028.1
24	Жаргалант СЭМТ	221.3	799.4	1,020.7
25	Их-Уул СЭМТ	358.1	855.0	1,213.1
26	Рэнчинлхүмбэ СЭМТ	316.8	836.9	1,153.6
27	Тосонцэнгэл СЭМТ	390.5	625.8	1,016.2
28	Төмөрбулаг СЭМТ	217.1	648.5	865.6
29	Түнэл СЭМТ	189.1	639.6	828.7
30	Улаан-Уул СЭМТ	245.2	805.6	1,050.8
31	Ханх СЭМТ	98.1	590.7	688.8
32	Хатгал СЭМТ	206.0	704.0	910.0
33	Цагааннуур СЭМТ	94.2	438.1	532.3
34	Цагаан-Уул СЭМТ	184.8	929.5	1,114.4
35	Цэцэрлэг СЭМТ	276.9	886.0	1,162.9
36	Цагаан-Үүр СЭМТ	258.4	584.5	842.9
37	Чандмань-Өндөр СЭМТ	152.4	586.0	738.3
38	Шинэ-Идэр СЭМТ	180.8	799.6	980.4
39	Эрдэнэбулган СЭМТ	239.9	541.4	781.3
40	Адонис /Нью Адонис фарма/	16.1	67.7	83.8
41	Ариун бат мөрөн ХХК / өсөх-эрдэнэ / эмийн сан	11.5	14.8	26.3
42	АЧИТ ЦАНГИС Цангис эмийн сан	10.8	10.5	21.4
43	Дагалдах -од ХХК / цогт өндөр эмийн сан/	31.0	44.9	76.0
44	Жинстфарм ХХК	61.3	69.4	130.6
45	ИДЭР ФАРМ ХХКИдэр эмийн сан	66.3	61.1	127.4
46	Их отгонтэнгэр ХХК /отгонтэнгэр эмийн сан	53.2	58.0	111.2
47	Лидэр өвс ХХК	4.4	36.8	41.2

48	Лили фарм ХХК	11.1	17.3	28.4
49	МАНДАХ ШИМ ХХКШим	63.1	56.2	119.3
50	МАРАЛ ОД ГАРИГ ХХК Марал-Одгариг	297.0	275.2	572.2
51	Мөнх-Ундрал ХХК	13.5	11.0	24.4
52	ОТОС НАМНАН ХХК Отос намнан -2 эмийн сан	52.2	57.9	110.1
53	Оюу өргөө фарм ХХК / оюу эмийн сан/	118.6	189.7	308.3
54	Хачин уул ХХК / хүрэл уул эмийн сан	14.9	26.7	41.6
55	Хишиг Ван ХХК / энхжин фарм /	3.7	5.0	8.7
56	Хойморь мөрөн ХХК /амар мэнд эмийн сан/	14.3	14.7	28.9
57	Хөвсгөл ивээл ХХК	10.0	14.0	24.1
58	Хөвсгөл монос ГХБ ХХК	34.9	36.8	71.8
59	ХӨВСГӨЛ ЭМ ХАНГАМЖ ХХКМЭИК-ийн хөвсгөл компани С	243.6	184.5	428.1
60	Хөгжил мөрөн ХХК / Үлэмж эмийн сан/	52.8	137.1	189.9
61	Хөх туг фарм ХХК	28.9	56.0	85.0
62	Үлэмж фарм эмийн сан	54.0	94.8	148.9
63	Хавтгай бадрах ХХК / ундрал эмийн сан/	11.8	7.7	19.6
64	ЭМ УВИДАС ХХК Увидас	12.2	5.4	17.5
65	Энх зүрх фарм	32.4	49.4	81.8
66	ЭНЭРЭХ ЭНЭРЭЛ ХХК Энэрэл	39.6	18.2	57.7
67	АЛАГ-ЭРДЭНЭ ЭМИЙН САН	9.7	-	9.7
68	Арбулаг эмийн сан	10.4	-	10.4
69	Баянзүрх эмийн сан	3.7	-	3.7
70	Бүрэнтогтох эмийн сан	24.9	1.5	26.4
71	Галт эмийн сан	6.5	-	6.5
72	Жаргалант эмийн сан	13.6	-	13.6
73	Их-Уул эмийн сан	13.6	-	13.6
74	Рашаант эмийн сан	13.2	-	13.2
75	Ренчинлхүмбэ эмийн сан	12.8	-	12.8
76	Тариалан эмийн сан	22.1	-	22.1
77	Тосон сайхан ХХК	5.1	26.2	31.3
78	Тосонцэнгэл эмийн сан	7.3	-	7.3
79	Төмөрбулаг эмийн сан	9.0	-	9.0
80	Түнэл эмийн сан	11.6	-	11.6
81	Улаан-Уул эмийн сан	9.0	-	9.0
82	Ханх эмийн сан	8.9	-	8.9
83	Хатгал эмийн сан	13.0	-	13.0
84	Цагааннуур эмийн сан	8.8	-	8.8
85	Цагаан-Уул эмийн сан	9.8	-	9.8
86	Цагаан-Үүр эмийн сан	5.8	-	5.8
87	Цэцэрлэг эмийн сан	4.9	-	4.9
88	Чандмань-Өндөр эмийн сан	10.8	-	10.8
89	Шинэ-Идэр эмийн сан	1.2	-	1.2
90	Эрдэнэбулган эмийн сан	10.6	-	10.6
91	Дэлгэрэх рашаан эмийн сан	-	17.7	17.7
92	Монос Хөвсгөл Эмийн сан	-	15.9	15.9
	Нийт:	26,472.2	39,138.7	65,610.9



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 19 өдөр

№ 71/2023.60463/ХАА-0023/19-
-21/ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хөвсгөл-Энэрэл” өрхийн эрүүл мэндийн төв нь 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 11,402,500 (Арван нэгэн сая дөрвөн зуун хоёр мянга таван зуу) төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг “Хөвсгөл-Энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ж.Алтанцэцэг, нягтлан бодогч Б.Туул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Д.ОТГОНБАЯР



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 19 өдөр

№ 72/АДХВОНБ/ХӨА-2023/
19-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Эрүүл мэндийн даатгалын хэлтэс” нь сумын эрүүл мэндийн төвүүдэд 2022 онд олгосон санхүүжилтийн тайланг 679,192,896.7 (Зургаан зуун далан есөн сая нэг зуун ерэн хоёр мянга найман зуун ерэн зургаан төгрөг далан мөнгө) төгрөгөөр илүү буюу зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.2. “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Аймгийн эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын тайланг зөрүүтэй гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Ж.Түвшинтөгс, мэргэжилтэн Г.Азаяа, М.Мягмаржав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Д.ОТГОНБАЯР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 14 өдөр

№ 73/АДВ-70489/ХМА-2023/
19-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Далай-Элбэрэлт” өрхийн эрүүл мэндийн төв нь 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 6,848,058 (Зургаан сая найман зуун дөчин найман мянга тавин найм) төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг “Далай-Элбэрэлт” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ц.Буяннэмэх, нягтлан бодогч Б.Туул нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7039-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 19 өдөр

№ 74/А2270469/ХАА-2023/
19-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 5 өрхийн эрүүл мэндийн төвийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 40,222,328.6 (дөчин сая хоёр зуун хорин хоёр мянга гурван зуун хорин найм) төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна. Энэ нь аймгийн Засаг дарга гуравласан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 3.5-д “Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд шилжүүлэхийг хориглоно”, Хөвсгөл аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байгуулсан гуравласан гэрээний 4.1.1-т “Аймгийн Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ: Төвийг эмнэлгийн зориулалтын байраар хангаж, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэн, тогтмол зардлыг хариуцан, төсвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтмол зардлыг санхүүжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатар нарт даалгасугай.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

1728090001 00000005



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 19 өдөр

№ 75/22271129/ХӨА-2023/
19-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Дэлгэр мөрөн” өрхийн эрүүл мэндийн төв нь 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 8,076,000 (Найман сая далан зургаан мянга) төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг “Дэлгэр мөрөн” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Б.Туул нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР Л.МӨНХ-ОРГИЛ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 19 өдөр

№ 76/АДЭТ/129/ХӨА-2023/
19-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Энх-Үйлс” өрхийн эрүүл мэндийн төв нь 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 4,902,550 (дөрвөн сая есөн зуун хоёр мянга таван зуун тавь) төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг “Энх үйлс” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Золзаяа, нягтлан бодогч Б.Туул нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР: Л.МӨНХ-ОРГИЛ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

Хавсралт №4

сая төгрөг

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛИЙН ХЯНАЛТЫН ХАСАЛТ 2021, 2022 ОН

№	Байгууллагын тоо	он	Нэхэмжилсэн		Хасалт						Нийт хасалт		Олгох санхүүжилт	
					Системийн		Эмчийн		Байцаагчийн					
			хүний тоо	дүн	хүний тоо	Дүн	хүний тоо	Дүн	хүний тоо	Дүн	хүний тоо	Дүн	хүний тоо	Дүн
1	90	2021	526,448	29,854.5	6,451	1,672.4	7,048	1,678.0	1,164	32.0	14,663	3,382.3	511,785	26,472.2
2	71	2022	446,438	41,637.3	7,872	1,263.0	6,403	1,181.9	984	53.6	15,259	2,498.5	431,179	39,138.7